



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/24


Улаанбаатар хот

Цус, цусан бүтээгдэхүүний тооллого хийх тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, мөн зүйлийн 12.2.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт, 71, 72, 73 дугаар зүйл, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2022 оны 49/А/118 дугаар тушаал, Төвийн "Тооллого явуулахад баримтлах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Төвийн цус, цусан бүтээгдэхүүний тооллого хийх комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Тооллогын бэлтгэл ажлыг хангахыг Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Х.Одгэрэл/-д даалгасугай.
3. Тооллогыг 2022 оны 5 сарын 02-06-ны өдрүүдэд зохион байгуулсугай.
4. Тооллогыг тогтоосон хугацаанд чанартай явуулж, дүнг "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-д, 2022 оны 05 дүгээр сарын 13-ны өдрийн дотор "Удирдлагын зөвлөл"-д тус тус танилцуулахыг тооллогын комиссын ахлагч /Ч.Батболд/-д даалгасугай.
5. Тооллогын дүнг үндэслэн нягтлан бодох бүртгэлд шинэчилсэн үнээр тусгахыг Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Х.Одгэрэл/-д үүрэг болгосугай.
6. Тушаалыг тооллогын комиссын бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБЯАР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны 05 дүгээр сарын 09-ны
өдрийн 000 дугаар тушаалын
хавсралт



Тооллогын комиссын бүрэлдэхүүн

Комиссын дарга: Ч.Батболд /Захиргаа, маркетингийн албаны дарга/

Гишүүд: Б.Додьгалсан /Инженер техникийн тасгийн эрхлэгч/
Б.Оргил /Үйлдвэрлэлийн тасгийн Технологич их эмч/
Б.Дуламсүрэн /мөн тасгийн Техноглогич сувилагч/
Н.Энхтуул /мөн тасгийн Техноглогич сувилагч/
Б.Ижилбаатар /Донор зохион байгуулалтын тасгийн Их эмч/
Ч.Далайцэрэн /Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн
албаны Мэдээллийн технологийн инженер/
Н.Тэрбиштогтох /Нэгдсэн лабораторийн тасгийн Лаборант/

Нарийн бичиг: Б.Алтанзул /Санхүү, бүртгэлийн албаны Тооцооны нягтлан
бодогч/